



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/НЗ

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 03/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл тайлагналт, Төрийн сангийн удирдлагын цахим системийн талаар сумдын Төсвийн ерөнхий нягтлан бодогч, Төлбөр тооцооны мэргэжилтэн, орон нутгийн байгууллагуудын Нягтлан бодогч нарыг чадавхжуулах, цаашид гарах алдаа, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад шаардагдах 3,892,500 (гурван сая найман зуун ерэн хоёр мянга таван зуу) төгрөгийг хавсралтаар баталсугай.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0820

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 44/НЗ дугаар захирамжийн хавсралт



СУРГАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын зүйл	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Сургалтын өдрийн хоол	75	27,100	2,032,500
2	Цайны зардал	150	5,000	750,000
3	Заалны түрээс	8	25,000	200,000
4	Ус бусад	7	30,000	210,000
5	Сургалтын хэрэглэгдэхүүн	70	10,000	700,000
Нийт дүн				3,892,500

-оОо-